

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2022 ОНЫ  
ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТ

2022-06-09

Бүтэц	№	Бодлогын баримт бичигт тусгагдсан, болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Төлөвлөсөн онд хүрэх түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Хувь
						2022		
<b>Үндсэн чиг үүргийн нэр: 6 Хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих</b>								
Зорилт	1	Эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдийн тоног төхөөрөмжийн хангалт 2019 онд 85.0 байсныг 2024 онд 86.7 хувьд хүргэнэ.	Хандив тусламж 79,8 сая УТ 519,2 сая	Тоног төхөөрөмжийн хангалтын хувь	85.0	85.9	Аймгийн Нэгдсэн эмнэлэгт Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтаар “Эрүүл мэндийг дэмжих төв”-ийн үйл ажиллагаанд зориулан 440,0 сая төгрөгийн Зөөврийн ЭХО аппарат, тархины доплер, чих хамар хоолойн эмчийн иж бүрдэл зэрэг 33 төрлийн тоног төхөөрөмж, Эрүүл мэндийн сайд орон нутагт ажиллахдаа 51,8 сая төгрөгийн ЭХО аппарат, өрх, сумдын эрүүл мэндийн төвүүдэд 88,9 сая төгрөгийн шүдний кресло/ком/, автоклав, биохимийн аппарат зэрэг 12 төрлийн тоног төхөөрөмж, “Хүннү ресорус” ХХК-ны хөрөнгө оруулалтаар 20,9 сая төгрөгийн тоног төхөөрөмжүүдийг тус тус олголоо. Тоног төхөөрөмжийн хангалтын хувь 88,0 хувьд хүрсэн	100
	1	Сумдын эрүүл мэндийн төвүүдийг мобайл технологиор хангах	-	Хангагдсан сумдын тоо	4	4	Мобайль технологээр хангах үйл ажиллагааны хүрээнд Говь-угтаал, Баянжаргалан, Өндөршил, Сайхан-овоо, Өлзийт сумдын эрүүл мэндийн төвүүдэд 60,0 сая төгрөгний	ХБ

Арга хэмжээ							төсөвтэйгээр төрийн худалдан авах газарт тендер зарлагдаж байна.	
	2	Эмнэлэг эрүүл мэндийн төвүүдийг оношилогоо, эмчилгээний дэвшилтэт тоног төхөөрөмжөөр хангах	Хандив тусламж 79,8 сая УТ 519,2 сая	Тоног төхөөрөмжийн хангалт Хувь	85.0	86.0	Нэгдсэн эмнэлэгт Зөөврийн ЭХО аппарат, тархины доплер, чих хамар хоолойн эмчийн иж бүрдэл зэрэг 33 төрлийн тоног төхөөрөмж, Эрүүл мэндийн сайд орон нутагт ажиллахдаа 51,8 сая төгрөгийн ЭХО аппарат, Өрх, сумдын эрүүл мэндийн төвүүдэд 88,9 сая төгрөгийн шүдний кресло/ком/, автоклав, биохимийн аппарат, Орон нутгийн хөгжлийн сангаар уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээнд ашиглах 69,0 сая төгрөгийн 18 төрлийн тоног төхөөрөмж, “Хүннү ресорус” ХХК-ны хөрөнгө оруулалтаар 20,9 сая төгрөг, тоног төхөөрөмжүүдийг тус тус олголоо. Тоног төхөөрөмжийн хангалтын хувь 88,0 хувьд хүрсэн	100
	3	Эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдийн автомашины парк шинэчлэлт, багийн эмч нарын унааг үе шаттай хийж, түргэн тусламжийн автомашиныг яаралтай тусламжийн тоног төхөөрөмжөөр тоноглох	УТ 60,1 сая	Автомашины хангалт хувь	90	93	Түргэн тусламжийн автомашин дутагдалтай байсан Дэлгэрхангай сумын эрүүл мэндийн төвд улсын төсвийн 44,9 сая төгрөгийн санхүүжилттэйгээр Фургон автомашин шинээр олголоо. Автомашины хангалтын хувь 93,0 хувьд хүрлээ.	100
			Тоноглогсон автомашины тоо	1	2	Дэлгэрхангай, Баянжаргалан Эрдэнэдалай сумдын эрүүл мэндийн төвүүдийн түргэн тусламжийн автомашиныг 15,2 сая тоног төхөөрөмжөөр тоноглолоо.		
				Багийн эмчийн унааны Тоо	1	8	<b>Хугацаа болоогүй</b>	
Зорилт	2	Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлтийг 2020 онд 83.0	Хандив тусламж 79,8 сая	Чанарын үзүүлэлтийн Хувь	83.0	84.0	Эмнэлэг эрүүл мэндийн төвүүдэд нийт 38 нэр төрлийн 599,0 сая төгрөгийн тоног төхөөрөмжөөр	100

		байсныг 2024 онд 85.0 хүргэнэ.	УТ 519,2 сая				хангагдснаар эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлтийг 85,0 хувьд хүрсэн.	
Арга хэмжээ	1	Явуулын тусламж, үйлчилгээгээр алслагдсан сум багийн иргэдийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах	-	Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан иргэдийн эзлэх хувь	29.7	31.8	Улаанбаатар хотын Лев-Мед ХХК-тай хамтран Хулд, Адаацаг, Сайхан-Овоо, Дэлгэрхангай, Эрдэнэдалай сумдад дотор, эмэгтэйчүүд, ЭХО, уушиг харшил, зүрх судасны цахилгаан бичлэг, оношилгоог алслагдсан сумын 3252 иргэдэд явуулын амбулаторийн тусламж үйлчилгээг үзүүллээ. Нийт үзүүлсэн иргэдийн 62,0 хувь нь ковидын дараах хам шинж, 29 хувь нь амьсгалын замын үрэвсэл, 10,1 хувь нь тоосны харшил, 9,7 хувь нь арьсны харшил, 32,5 хувь нь даралт ихсэх, 20,0 хувь нь цээжний бах, 23,9 хувь нь бөөрний үрэвсэл, 21,9 хувь нь нойр булчирхайн үрэвсэл, 19,67 хувь нь ходооны архаг үрэвсэл тус тус оншилогдсон байна. Бөөрний хавдар 3-ийг илрүүлэн 3 дахь шатлалын эмнэлэгт илгээлээ. Урьдчилан сэргийлэх үзлэгийн хамрагдалтын хувь 16,4, өвчлөл илэрсэн иргэдийн эрүүлжилтийн 25,0 хувьтай байна.	40,1
	2	Хот хоорондын зам дагуу болон алслагдсан сумдад яаралтай тусламжийн цэг байгуулах	УТ 1,2 сая	Цэг байгуулсан сумдын тоо	1	1	Хулд, Дэлгэрцогт, Луус сумдад нийт яаралтай тусламжийн 3 цэгийг байгуулснаар авто осол 4, бусдад зодуулсан 3, хугарал бэртэл 5, нохойд уруулсан 3 ,түлэгдэлт 5, хурц зүйлийн нөлөөтэй гэмтэл 3, угаартсан 1 тус тус чиглэлээр нийт 24 хүнд тусламж үйлчилгээ үзүүлсэн.	100
	3	Олон улсын эмнэл зүйн UP TO DATE 'програмыг эмч бүр ашиглах,алсын зайн	УТ 34,0 сая	Ашиглалтын хувь	0	80	2021 оноос эхлэн UP TO DATE цахим платформыг ашиглаж эхэлсэн бөгөөд нийт эмч, эмнэлгийн	100

	оношлогоо, зөвлөгөө авах нөхцөлийг бүрдүүлж эмч нарыг компьютер тоног төхөөрөмжөөр хангах					мэргэжилтний 80,0 хувь нь ашиглаж байна.	
			Хангалтын хувь	45	80	Эрүүл мэндийн газар, 15 сумын эрүүл мэндийн төвүүдэд оношилгоо, эмчилгээ, зөвлөгөө, бүртгэл мэдээлэлд зориулан улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 34 сая төгрөгний үнэ бүхий 1 суурин компьютер, 15 зөөврийн компьютерээр хангагдсан. Хангалтын хувь 95,0	
4	Эхийн эндэгдэлгүй ажиллаж, хүүхдийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулж 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг бууруулах	-	Эхийн эндэгдэл /100 000 амьд төрөлт/Просантим иль	0	0	Жирэмсний хяналтын чанарын сайжруулах ажлын хүрээнд аймгийн төвийн 2 өрх, Дэрэн сумын эрүүл мэндийн төвийн эх баригчдыг “Ажлын байрны дадлагажуулах 10 хоног”-ийн сургалтад цахимаар 2, танхимын сургалт 1 удаа тус тус хамрууллаа. Жирэмсний хяналтад шинээр 293 жирэмсэн эх хамрагдснаас жирэмсний эрт үеийн хяналт 92,8 хувьтай байна. Эхний 5 сарын байдлаар нийт 281 эх төрсөн бөгөөд нийт төрөлтийн 95,4 хувь нь аймгийн нарийн мэргэжлийн эмчийн хяналтад төрж, жирэмсэн төрөх, төрсний дараах үеийн хүндрэл бүртгэгдээгүй. Эхийн эндэгдлийн тохиолдол бүртгэгдээгүй. Жирэмсний эрт үеийн хяналт 92,8 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 4,0 хувиар өссөн үзүүлэлттэй байна.	100
			5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл /1000 амьд төрөлт/Промиль	10.0	9.5	5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд) 3,6 промиль байна. Өнгөрсөн оны мөн үетэй	

							харьцуулахад 4,2 промилиор буурсан үзүүлэлттэй байна.	
Зорилт	3	Халдварт бус өвчлөлийн түвшинг 2020 оны 7441.5 байсныг 2024 онд 7241.5 болгож бууруулна.	ЭМД-ын сан	10000 хүн амд ногдох халдварт бус өвчлөлийн түвшин Промиль	7441.5	7341.5	2022 оны эхний 5 сарын байдлаар зонхилон тохиолдох халдварт бус өвчлөл артерийн гипертензийн эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих 12073 иргэнээс 3488 буюу (28,9%), чихрийн шижин өвчний эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих 12974 иргэн хамрагдахаас 3532 буюу (27,2%), умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих 2568 иргэн хамрагдахаас 712 буу (27,7%), хөхний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт 8398 иргэн хамрагдахаас 1441 буюу (17,2%) хамрагдаж, аймгийн хэмжээнд эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалт 25,3%-тай байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 5,3%-иар буурсан үзүүлэлттэй байна. Эрт илрүүлэг үзлэгээр артерийн гипертензитэй 49, чихрийн шинжинтэй 6 иргэнийг тус тус илрүүлэн хяналтад авлаа. 10000 хүн амд халдварт бус өвчний түвшин 3142,9 промилль байна.	100
	1	Иргэн, өрх гэр бүл, байгууллага, хамт олонд түшиглэн эрүүл мэндэд ээлтэй орчинг бүрдүүлэх.	■	Эрүүл мэндийг дэмжигч эрүүл мэндээ дээдлэгч иргэний тоо	37	43	“Эрүүл мэндийг дэмжигч байгууллага”, “Эрүүл ажлын байр”, “Эрүүл мэндээ дээдлэгч өрх, гэр бүл, иргэн” шалгаруулах болзолт уралдааныг зарлаж, журам, шалгуур үзүүлэлтийг Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны 211 тоот албан бичгээр төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгжүүдэд хүргүүлээ. Шалгаруулалтыг 2022 оны 11 дүгээр сард зохион байгуулна.	ХБ

Арга хэмжээ				Хог хаягдлын автоклаваар хангагдсан ЭМБ-ын тоо	0	5	Өрх, сумын эрүүл мэндийн төвүүдэд 12 ширхэгийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар захиалан тендер шатандаа явагдаж байна.	
	2	Хүн амын дунд өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгаан болж буй өвчлөлийг бууруулах олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлэх .	ЭМДС 5,3 сая	Урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан хүн амын хувь	29.7	33.6	“Хүн амыг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан халдварт болон халдварт бус өвчний урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, шинжилгээ, оношилгоо”-нд 0-17 насны 16752 хүүхэд хамруулахаас 90-ээс доошгүй хувийг, насанд хүрэгчдийн 4 насны багцын үзлэгт хамрагдвал зохих нийт 30790 хүнээс 30-аас доошгүй хувийг хамруулахаар төлөвлөлт хийгдлээ. Урьдчилан сэргийлэх үзлэгт 16,4 хувийг хамруулсан байна.	38,9
				Эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалтын хувь	57.8	62.6	Эрүүл мэндийн сайдын 2022 оны 139 дүгээр тушаалаар шинэчилэгдсэн “Хүн амыг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан халдварт болон халдварт бус өвчний урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, шинжилгээ, оношилгоо”-ны журмыг хэрэгжүүлэх хүрээнд харьяа эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдийн 3 удаагийн цахим хурлаар, 6 удаагийн албан бичгээр ажлын чиглэл, зөвлөмжийг өглөө. Насанд хүрэгчдийн багц үзлэг болон хүүхдийн үзлэгийг зохион байгуулах эмнэлгийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд Эрүүл мэндийн хөгжлийн төвтэй хамтран график сургалтад бүрэн хамруулж чадавхжууллаа. Зорилтот насны иргэдийг хамруулах үзлэгийн үйл ажиллагааны нээлтийг 2022 оны 5 дугаар сарын 1-ний	

							өдрөөс аймгийн хэмжээнд эхлүүлж одоогийн байдлаар нийт 135 хүнийг хамруулаад байгаа бөгөөд хамрагдвал зохих иргэдийн 0,4 хувийг эзэлж байна.	
				Эрүүл мэндийн боловсрол олгосон хүн амын эзлэх хувь	59.4	69.4	Монгол Улсын Засгийн Газрын 2001 оны 224 дүгээр тогтоолын дагуу 2022 оны эхний 5 сарын байдлаар “Осол гэмтлээс сэргийлье”, Охид, эмэгтэйчүүдийн эрүүл мэнд”, “Эрчүүдээ хайрлая”, “Давсны хэрэглээгээ багасгая”, “Идэвхтэй дасгал хөдөлгөөний ач тус”, “Архи, тамхи хорт зуршлаас татгалзая”, “Сүрьеэгийн халдвараас сэргийлье” зэрэг өдрүүдийг төлөвлөгөөний дагуу зохион байгуулж нийт 33500 хүнд мэдээлэл сургалт сурталчилгаа хийж 6 удаа сургалт зохион байгууллаа. Нийт хүн амын 74,4 хувийг эзэлж байна.	
3	Нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үеийн нөөцийн бэлэн байдал, хариу арга хэмжээ шуурхай авах чадавхийг бүрдүүлэх, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, дархлаажуулах үйл ажиллагааг өргөжүүлэх.	УТ 202,2 сая Хандив тусламж 1,5 сая	Гамшгийн үеийн эм, эмнэлгийн хэрэгсэлийн нөөцийн хангалтын хувь	50.0	55.8	2022 оны эхний 5 сарын байдлаар Коронавируст халдварын батлагдсан шинэ тохиолдол 2724 бүртгэгдэж өссөн дүнгээрээ 15128 болсон байна. 2704 тохиолдлын ойрын хавьтал 3147 хүнд тандалт судалгааг хийн, 1, 2-р хавьтлын хүнийг илрүүлэн хяналтад авч, түргэвчилсэн шинжилгээ болон баталгаажуулах шинжилгээнд хамрууллаа. Өнөөдрийн байдлаар эмчлэгдэж байгаа 4 хүн байна. Коронавирусын халдварын тархалтын түвшин “Халдварын тархалт бага буюу ногоон” түвшинд байна. Эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдийн шинэ болон сэргэн тархаж байгаа халдварын үед хэрэглэх эмнэлгийн	97,8	
			Гамшгийн үеийн тоног төхөөрөмжийн хангалтын хувь	78.0	82.9			

							эмийн хангалтын хувь 86,6 хувь, тоног төхөөрөмжийн хангалт 83,6%-тай байна.	
			-	Дархлаажуулалтын хамралтын хувь	94.4	95.5	Дархлаажуулалтын 1-р тунгийн хамрагдалтын хувь 79,5% , 2-р тунгийн хамрагдалтын хувь 76,3%, 3-р тунгийн хамралтын хувь , нэмэлт тунгийн хамралт 47,2% хувь байгаа бөгөөд дундаж хамрагдалтын хувь 77,9 байна.	
ХЭРЭГЖИЛТИЙН ДУНДАЖ ХУВЬ-								84,6

ХЭРЭГЖИЛТ ГАРГАСАН:  
УТСХ-ИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

П.ОЮУНЧИМЭГ

ХЯНАСАН:  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА

Б.АЛТАНТӨГС